

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 06 дугаар сарын 21

Дугаар 73

Улаанбаатар хот

Энгийн хог хаягдлыг цуглуулж тээвэрлэх зардлын
нэгж тариф шинэчлэн батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.16, 20.3 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.10 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх заалт, Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 192, А/243 дугаар хамтарсан тушаалыг тус тус үндэслэн Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын арван хоёрдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Хог хаягдлын цуглуулалт, тээвэрлэлтийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор энгийн хог хаягдал цуглуулж, тээвэрлэх зардлын нэгж тарифыг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тогтоолын хавсралтад заасан нэгж тарифыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ өөрчлөгдөхөд өөрчлөгдсөн дүнгийн 0,35 хувиар, шатахууны үнэ өөрчлөгдөхөд өөрчлөгдсөн дүнгийн 0,24 хувиар тус тус нэмэгдүүлэн өөрчилж тооцсугай.

3. Тогтоол батлагдсантай холбогдуулан Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 33 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (Ч.Мэндсайхан)-д үүрэг болгосугай.

ДАРГА

А.БАЯР

Баянзүрх дүүргийн иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 06
дугаар сарын-ний өдрийн арван
хоёрдугаар хуралдааны дугаар
тогтоолын хавсралт

ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ ЦУГЛУУЛЖ, ТЭЭВЭРЛЭХ ЗАРДЛЫН
НЭГЖ ТАРИФ

Д/д	Хогийн төвлөрсөн цэг хүртэлх зай	1 км зайд 1 тонн хог тээвэрлэх тариф
1	1-10 км	5800
2	11-15 км	5330
3	16-20 км	4712
4	21 км ба түүнээс дээш	4034